



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/164

Хэрлэн сум

Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах
бэлэн байдлын үзлэгийг зохион явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах зорилгоор “Аймгийн Засаг даргын нэрэмжит” гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрүүдэд сумдад зохион байгуулсугай.

2.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах удирдамжид заагдсан чиглэлээр бэлтгэлийг хангаж үзлэгт хамрагдахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг явуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах үзүүлэлт, үнэлгээ өгөх хүснэгтийг хоёрдугаар хавсралтаар, үзлэг явуулах сумдын хуваарийг гуравдугаар хавсралтаар, гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах алба хаагчдын томилолт, тээврийн хэрэгслийн шатахууны зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

4.Хөрөнгө зарцуулалтад шаардагдах 6,057,440 (зургаан сая тавин долоон мянган дөрвөн зуун дөч) төгрөгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

2.

5.Гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ж.Эрдэнэбат)-д, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 21-ны өдрийн
А/164 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**ХЭНТИЙ АЙМГИЙН “ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ”
БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГИЙН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Орон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах. Хаврын хуурайшилт эхэлж ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан сум, тосгодын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх томилгоот бүрэлдэхүүн, түймэр унтраах ашиглах техник, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, үнэлгээ өгөх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа хийхэд чиглэгдэнэ.

Хоёр. Ажлын чиглэл

Бэлэн байдлын үзлэг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь Улсын Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгавар, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны “Журам батлах тухай” А/315 дугаар тушаал, Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг зохион байгуулах, үнэлэх журмын хэрэгжилтийг хангах.

Сумдад дараах байдлаар шалгалтыг зохион байгуулж үнэлгээ дүгнэлт өгнө. Үүнд:

1. Сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт, түүний хэрэгжилт.
2. Гамшгаас хамгаалах ангиллын сургалт түүний үр дүн.
3. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн мэдлэг чадвар.
4. Засаг даргын үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах чиглэлээр тусгагдсан арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжилт.
5. Гамшгаас хамгаалах дайчилгаа нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт, зохион байгуулалт, хүч хэрэгслийн бүртгэл тооцоо.
6. Орон нутгийн гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, хуулийн этгээдийн галын аюулгүй байдлыг хангах, бэлтгэл бэлэн байдал.
7. Гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэлт
8. Гамшгаас хамгаалах удирдлага зохион байгуулалт
9. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байдал
10. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төсөв санхүүжилт
11. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулагдсан аврах ажлын техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөхөн хангалт, ашиглалт, хадгалалтын байдал.
12. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагаас гаргасан төлөвлөгөө, түүний хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түймэр унтраах техник багаж, хэрэгсэлтэй танилцах үнэлгээ өгөх
13. Сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулах
14. Гамшгаас хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоол, түймрийн хохирлын акт тогтоох аргачлалаар сургалт зохион байгуулах.

Гурав. Бэлэн байдлын үзлэг явуулах хугацаа, бүрэлдэхүүн

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг аймгийн Онцгой байдлын газрын Орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч ахмад Б.Бат-Эрдэнэ, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч ахмад О.Баярмагнай, Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахмад Б.Болор-Эрдэнэ, ахмад Р.Мөнхдорж,


Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн албаны дарга Э.Батсайхан, ойн нөхөн сэргээлт, цөлжилт хариуцсан мэргэжилтэн Б.Гүрсүрэн, жолооч а/а Х.Халы, И.Зоригтбаатар нарын хамтарсан 8 хүний бүрэлдэхүүнтэй 2 ажлын хэсэг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 21-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулна.

Дөрөв. Зохион байгуулалтын талаар

Удирдамжид заагдсан ажлын бичиг баримтыг бүрдүүлж 2 хувь үйлдэх, үзлэгт томилгоот бүрэлдэхүүн, машин техник, багаж хэрэгслийг бүрэн хамруулах, ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагыг оролцуулах бөгөөд сумын Засаг дарга өөрийн биеэр удирдан зохион байгуулна. Ажлын хэсэг үзлэгийн дүнг сумын Засаг даргад танилцуулж баталгаажуулах ба үзлэгийн үр дүнгийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллана.

Тав. Дүнгийн талаар

Аймгийн Засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн дүнг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/315 тушаал "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах, үнэлэх журам"-ын 5,2-т заасны дагуу дүгнэж аймгийн Засаг даргад 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр тайлагнаж үзлэгээр хангалтгүй дүгнэгдсэн сумын Засаг дарга, холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож зөрчил дутагдлыг арилгуулна.



Аймгийн Засаг даргын 2023 оны
 дугаар сарын 21-ны өдрийн
 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах
 үзүүлэлт, үнэлгээ өгөх хүснэгт

д/д	Шалгах үзүүлэлт	Оноо авах нөхцөл	Оноо
1	2	3	4
Шалгах үзүүлэлт 1			
1.1 Гамшгийн эрсдэлийн үнэлгээ			
1.1.1	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ эрсдэлийн хийлгэсэн байдал	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн бол	+15
1.2 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилт			
1.2.1	Гамшгаас төлөвлөгөө, хэрэгжилт хамгаалах түүний	Төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулсан, гамшгийн үед болон дадлага, сургуулиар тодотгосон бол	+20
1.3 гамшгаас хамгаалах ангиллын сургалт түүний үр дүн			
1.3.1	Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан болон ажилтан болон иргэнд гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулсан, ухуулга, сурталчилгааны ажил хийсэн байдал	Удирдах албан тушаалтны сургалт	+10
		Оюутан, сурагчийн сургалт	+5
		Хуулийн этгээдийн сургалт	+10
		Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн сургалт	+10
		Сайн дурын хэсгийн	+10
		Иргэдийн сургалт	+10
		Гамшгаас хамгаалах ухуулга, сурталчилгааны ажлын төлөвлөлт, хэрэгжүүлсэн байдал	+5
		Гамшгийн эрсдэл эмзэг байдлыг бууруулах арга хэмжээг зохион байгуулж үр дүнд хүрсэн бол	+5
Авбал зохих оноо			100
Шалгуур үзүүлэлт 2			
2.1	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн мэдлэг чадвар		
2.1.2	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, чадвар, үйл ажиллагааны жигдрэлт, бэлэн байдал	Мэргэжлийн анги, сайн дэрын хэсгийн бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах мэдлэг дадлагыг бүрэн эзэмшүүлсэн байвал	+20
		Алба, мэргэжлийн ангид хөтлөгдөх бичиг баримтыг бүрэн хөтөлсөн бол	+10
		Өгөгдсөн цагийн байдлыг үнэлж, шийдвэрээ зөв гаргах, илтгэх чадварыг эзэмшсэн бол	+10
		Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг удирдах чадварыг сайн эзэмшсэн бол	+10
		Алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагаа жигдэрсэн байдал	+10
		Урьдчилан сэргийлэх ажилд хөрөнгө төлөвлөсөн эсэх, түүний зарцуулалт, үр дүн	+10
		Иж бүрэн, команд штабын сургуульд оролцож амжилттай үр дүн үзүүлсэн, бие бүрэлдэхүүний мэдлэг чадвар сайн бол	+10
		Хүн нэг бүрийн хээрийн үүргэвч, хөдөлмөр хамгааллын хувцасны хангалтын байдал, хээрийн нөхцөлд үүрэг гүйцэтгэх боломж	+20
Авбал зохих оноо			100
Шалгуур үзүүлэлт 3			
3.1 Засаг даргын үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах чиглэлээр тусгагдсан арга хэмжээ тэдгээрийн хэрэгжилт			
3.1.1	Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт гамшгаас	Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх заалт тусгагдсан бол	+20

	хамгаалах чиглэлээр тусгагдсан арга хэмжээ	Энэ заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнд хүрсэн бол	+20
3.2 гамшгаас хамгаалах дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт, зохион байгуулалт, хүч хэрэгслийн бүртгэл, тооцоо			
3.2.1	Гамшгаас хамгаалах дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлт	Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хүн, хүч хэрэгсэл дайчлах төлөвлөгөө боловсруулсан бол	+20
		Гамшгийн үед ард иргэдийг нүүлгэн шилжүүлэх газрыг тодорхойлж төхөөрөмжилсэн бол	+20
		Шаардлагатай хүн хүч техник хэрэгслийн тооцоо, судалгаатай бол	+10
		Нисдэг тэрэг нисэх, буух газрыг тодорхойлсон бол	+10
Авбал зохих оноо			100
Шалгуур үзүүлэлт 4			
4.1 Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, хуулийн этгээдийн галын аюулгүй байдлыг хангах бэлтгэл, бэлэн байдал			
4.1.1	Гал унтраах бэлтгэл бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилт	Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх үндэслэлтэй, бодит байдалд нийцүүлэн боловсруулсан бол	+5
		Бие бүрэлдэхүүнд гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах арга, дадал эзэмшүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулсан бол	+20
		Төлөвлөгөөний тодотгол хэрэгжилт, үр дүн сайн бол	+5
		Гал унтраах бүлэг, томилгоожуулсан байдал, үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, чадвар, бие бүрэлдэхүүн үүргээ бүрэн мэддэг, өөрийгөө хасгаалах бусдад туслах арга барилыг эзэмшсэн бол	+10
		Мэргэжлийн ангийн дарга, бүлгийн ахлагч нар гал түймрийн аюулын үед бие бүрэлдэхүүнийг удирдах, дадлага, чадварыг бүрэн эзэмшсэн бол	+10
4.2 Гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэлт			
4.2.1	Гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэлт	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хүрсэн бол	+10
		"Гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх, зарцуулах журам" боловсруулсан байдал (аймаг, нийслэл)	+20
		Сумын гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэлт	+20
Авбал зохих оноо			100
Шалгуур үзүүлэлт 5			
5.1 Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулах			
5.1.1	Удирдлага зохион байгуулалт	Удирдах бүрэлдэхүүний гамшгийн үед гүйцэтгэх үүргийн мэдлэг, шийдвэр гаргалт, байр зүйн зурагт ажиллах чадвар	+20
		Удирдлагын үүргийн зохиоцуулалт, бие бүрэлдэхүүнийг удирдах ур чадварыг эзэмшсэн байдал	+20
		Байнгын удирдлагын байрыг тоноглогсон байдал, техник хэрэгслийн хангалт	+10
		Хээрийн хөдөлгөөнт удирдлагын байр, түүний хээрийн бэлтгэл (хүнс, усны хангалт, шатахууны нөөцийн байдал, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдал)	+10
5.2 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төсөв, санхүүжилт			
5.2.1	Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төсөв, санхүүжилт	Тухайн жилийн төсвийн 1,0 хувийг орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулж үр дүнд хүрсэн бол	+20
		Орон нутгийг хөгжүүлэх сангийн төсвөөр гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэж үр дүнд хүрсэн бол	+20

Авбал зохих оноо		100	
Шалгуур үзүүлэлт 6			
6.1 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулагдсан аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөхөн хангалт, ашиглалт, хадгалалтын байдал			
6.1.1	Гамшгаас хамгаалах аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангалт	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгийн үед хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрдүүлсэн бол	+20
		Инженерийн болон бусад төрлийн багаж, техник хэрэгслийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангасан бол	+20
		Хүн нэг бүрийн гамшгийн үед ашиглагдах тоног төхөөрөмж багаж хэрэгслийн хангалт хүрэлцээтэй бол	+20
		Багаж хэрэгслийн засвар, үйлчилгээ, хадгалалт, эвдрэл гэмтлийг засварласан бол	+20
		Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангалт, түүний чанар байдал, ашиглалт, хадгалалт сайн бол	+20
Авбал зохих оноо		100	

Аймгийн Засаг даргын 2023 оны
 03 дугаар сарын 21-ны өдрийн
 А/164 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

**СУМДАД БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ, ШАЛГАЛТ
 ХИЙХ АЖЛЫН ХУВААРЬ**

д/д	Сумдын нэрс	Ажиллах хугацаа	Ажиллах хоног
1 дүгээр ажлын хэсэг			
1	Мөрөн сум	4 дүгээр сарын 10	1
2	Өлзийт тосгон	4 дүгээр сарын 10	
3	Өмнөдэлгэр сум	4 дүгээр сарын 11	1
4	Гурванбаян тосгон	4 дүгээр сарын 11	
5	Батширээт сум	4 дүгээр сарын 12	1
6	Биндэр сум	4 дүгээр сарын 13	1
7	Баян-Адарга сум	4 дүгээр сарын 14	1
8	Дадал сум	4 дүгээр сарын 15	1
9	Норовлин сум	4 дүгээр сарын 16	1
10	Батноров сум	4 дүгээр сарын 17	1
11	Бэрх тосгон	4 дүгээр сарын 18	1
12	Тахилгат тосгон	4 дүгээр сарын 19	1
	Нийт		10
2 дугаар ажлын хэсэг			
1	Жаргалтхаан сум	4 дүгээр сарын 10	1
2	Цэнхэрмандал сум	4 дүгээр сарын 11	1
3	Дэлгэрхаан сум	4 дүгээр сарын 12	1
4	Хэрлэнбаян- Улаан тосгон	4 дүгээр сарын 12	
5	Баянмөнх сум	4 дүгээр сарын 13	1
6	Дархан сум	4 дүгээр сарын 14	1
7	Бор-Өндөр сум	4 дүгээр сарын 15	1
8	Галшар сум	4 дүгээр сарын 16	1
9	Баян-Овоо сум	4 дүгээр сарын 17	1
10	Баянхутаг сум	4 дүгээр сарын 18	1
11	Хэрлэн сум	4 дүгээр сарын 19	1
	Нийт		10

Аймгийн Засаг даргын 2023 оны
 дугаар сарын 21-ны өдрийн
 дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

А/164 03

**ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН БЭЛЭН БАЙДЛЫН
 ҮЗЛЭГ ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Томилолтын зардал

д/д	Алба хаагчдын нэрс	Албан тушаал	Ажиллах хоног	Томилолтын зардал (1 хоног)	Нийт зардал
1	Б.Бат-Эрдэнэ	Орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, ахмад	10	64,000	640,000
2	О.Баярмагнай	Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад	10	64,000	640,000
3	Б.Гүрсүрэн	Ойн нөхөн сэргээлт, мод үржүүлгэ хариуцсан мэргэжилтэн	10	64,000	640,000
4	Э.Батсайхан	Ойн ургамлын ашиглалт хамгаалалт, ой хээрийн түймэр хариуцсан мэргэжилтэн	10	64,000	640,000
5	Б.Болор-Эрдэнэ	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад	10	64,000	640,000
6	Р.Мөнхдорж	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад	10	64,000	640,000
7	И.Зоригтбаатар	Жолооч	10	64,000	640,000
8	Х.Халы	Жолооч	10	64,000	640,000
Нийт – 5,120,000					

Шатахууны зардал

д/д	Сумдын нэрс	Хоорондын зай (км)	Шаардагдах шатахуун (л)	Шатахууны үнэ (1л-2520)
1 дүгээр ажлын хэсэг				
1	Чингис - Мөрөн	30	5.4	14,616
2	Мөрөн - Өлзийт	50	9	22,680
3	Өлзийт - Өмнөдэлгэр	120	21,6	54,432
4	Өмнөдэлгэр - Гурванбаян	73	13,14	33,113
5	Гурванбаян – Батширээт	105	18,9	47,628
6	Батширээт-Биндэр	97	17,5	44,100
7	Биндэр- Баян-Адарга	55	10	25,200
8	Баян-Адрага – Дадал	120	21,6	54,432
9	Дадал - Норовлин	79	14,3	36,036
10	Норовлин - Батноров	110	19,8	49,896
11	Батноров - Бэрх	35	6,3	15,876
12	Бэрх - Тахилгат	70	12,6	31,752
13	Тахилгат -Чингис	60	10,8	27,216
	дүн	1004	181	456,120
2 дугаар ажлын хэсэг				
1	Чингис-Жаргалтхаан	100	18	45,360
2	Жаргалтхаан-Цэнхэрмандал	50	9	22,680
3	Цэнхэрмандал- Хэрлэнбаян-Улаан	140	25,2	63,504
4	Хэрлэнбаян-Улаан – Дэлгэрхаан	50	9	22,680
5	Дэлгэрхаан - Баянмөнх	80	14,4	36,288
6	Баянмөнх - Дархан	45	8,1	20,412
7	Дархан - Бор-өндөр	45	8,1	20,412
8	Бор-өндөр -Галшар	130	23,4	58,968
9	Галшар - Баянхутаг	120	21,6	54,432
10	Баянхутаг - Баян-Овоо	150	27	68,040
11	Баян-Овоо -Чингис	150	27	68,040
	дүн	1060	191	481,320
	Нийт дүн	2064	372	937,440

Нийт зардал

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн Үнэ	Нийт үнэ
1	Томилолт	8*10 хүн (хоног)	64,000	5,120,000
2	Шатах тослох материал (А-92)	Шатахуун -2064 км-т 372л	А-92 - 2520 төг	937,440
Бүгд – 6,057,440				